



Нислэгийн мэдээллийн ажилтны анхан шатны сургалт

1. Сургалтын зорилго:

Нислэгийн мэдээллийн ажилтан бэлтгэх сургалтад суралцсанаар суралцагчид нислэгийн мэдээллийн ажилтны мэргэжил эзэмшиж, уг мэргэжилд тавигдсан шаардлагын дагуу ажиллах ур чадвар дадлагыг олгоход оршино.

2. Суралцагчдад тавигдах шаардлага:

- 21 нас хүрсэн
- Дээд боловсролтой
- Англи хэлний дунд түвшний мэдлэгтэй байх (Intermediete)
- Компьютерийн хэрэглээний программ эзэмшсэн байх
- Сэтгэлзүйн шалгалтад тэнцсэн байх

3. Сургалтын агуулга:

- Иргэний нисэхийн байгууллагуудын танилцуулга
- Нисэхийн хууль тогтоомжийн талаарх ерөнхий ойлголт
- Аюулгүй байдал
- Аэродромын талаарх ойлголт
- Навигацийн тухай ойлголт
- Тоног төхөөрөмж ба системүүдийн талаарх ойлголт
- Цаг уурын тухай ойлголт
- Нисэхийн мэдээллийн үйлчилгээний талаарх ойлголт
- Нислэгийн хөдөлгөөний төлөвлөлт
- Нисэхийн англи хэл
- Агаарын зай, нислэгийн дүрмүүдийн тухай ойлголт
- НХУ-ний үйл ажиллагаатай холбогдох дүрэм, журмын тухай ойлголт
- НХУ-ын зөвшөөрөл
- Нислэгийн онцгой тохиолдол, нөхцөлийн үеийн үйл ажиллагаа
- Үйлдвэрлэлийн дадлага
- Танилцах аялал

4. Сургалтын орчин /танхим цахим/:

Танхим

5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:

480 цаг 12 долоо хоног

6. Анги дүүргэлт:

15-20 суралцагч



Иргэний нисэхийн аюулгүй хамгаалалтын ахлах ажилтны сургалт

1. Сургалтын зорилго:

Иргэний нисэхийн аюулгүй хамгаалалтын үйлчилгээний байгууллага, нисэх буудлын аюулгүй байдлын удирдах ажилтан, мэргэжилтэн менежер, ээлжийн ахлах ажилтнууд ажил үүргээ гүйцэтгэх явцад үүсэж болзошгүй нөхцөл байдалд тухайн сэдвийн талаарх бүрэн мэдлэгээ ашиглаж шийдвэр гаргах чадвар, дадлагыг эзэмшүүлнэ.

2. Суралцагчдад тавигдах шаардлага:

Аюулгүй байдлын ажилтнуудыг удирдан зохион байгуулах ахлах ажилтан (Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагын ахлах ажилтнууд, нисэх буудлын аюулгүй байдлын ахлах ажилтнууд) байна.

3. Сургалтын агуулга:

- Аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалтын орчны шинэчлэлт, өөрчлөлт
- Аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа
- Аюултай ачаа
- Иргэний нисэхийн эсрэг заналхийлэл
- Бусад

4. Сургалтын орчин /танхим цахим/:

Танхим болон цахим

5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:

40 цаг буюу 5 өдөр

6. Анги дүүргэлт:

15-аас ихгүй байна.



Аюулгүй байдлын мэдлэг олгох сургалт /НХҮА, ХНАА-ны ажилтнууд/

1. Сургалтын зорилго:

ИН-ийн эсрэг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах болон аюулгүй байдлын эрсдэл болон учирч болзошгүй аюул заналхийлэлд нисэх буудал болон агаарын навигацийн байгууламжид ажил үүрэг гүйцэтгэдэг инженер теникийн ажилтнууд, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны ажилтнуудын анхаарлыг хандуулж, тэдгээрийн нисэхийн аюулгүй байдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх.

2. Суралцагчдад тавигдах шаардлага:

-

3. Сургалтын агуулга:

- ИН-ийн аюулгүй байдлын талаарх үндсэн ойлголт
- ИН-ийн эсрэг заналхийлэл, авах арга хэмжээ

4. Сургалтын орчин /танхим цахим/:

Танхим болон цахим

5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:

8 цаг буюу 1 өдөр

6. Анги дүүргэлт:

15-20 суралцагч байна.



Хүний хүчин зүйлийн сургалт

1. Сургалтын зорилго:

Иргэний нисэхийн салбарын ажилтнуудад хүний хүчин зүйлийн талаарх суурь ойлголтыг олгох.

2. Суралцагчдад тавигдах шаардлага:

Иргэний нисэхийн салбарын ажилтан байх.

3. Сургалтын агуулга:

- Хүний хүчин зүйлийн ерөнхий ойлголт
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

4. Сургалтын орчин /танхим цахим/:

Танхим болон цахим

5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:

8 цаг буюу 1 өдөр

6. Анги дүүргэлт:

20-иос доошгүй суралцагч байна.



Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн давтан сургалт

1. Сургалтын зорилго:

Нислэгийн урсгалыг аюулгүй үр ашигтай төлөвлөж сурах ур чадварыг эзэмших, нислэгийн урсгал төлөвлөлт, зөвшөөрлийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагуудыг өөрийн ажлын байранд мөрдөж ажиллах.

2. Суралцагчдад тавигдах шаардлага:

Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн анхан шатны сургалтад хамрагдсан байх

3. Сургалтын агуулга:

- Эрх зүйн баримт бичгүүдийг сэргээн санах
- Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийг хэрэгжүүлэх
- Хамтын шийдвэр гаргалтыг хэрэгжүүлэх

4. Сургалтын орчин /танхим цахим/:

Цахим/ танхим

5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:

32 цаг буюу 4 өдөр

6. Анги дүүргэлт:

10-15 суралцагч байна.



Уламжлалт навигац ашигласан хэрэглэлийн нислэгийн журам зохиох анхан шатны сургалт

1. Сургалтын зорилго:

Суралцагчийг Уламжлалт навигац ашигласан нарийвчлалгүй оролт үйлдэх (non-RNAV NPA procedures) болон нисэн ирэх ба гарах журам (non-RNAV NPA procedures)-уудыг зохиох онолын мэдлэг олгох.

2. Суралцагчдад тавигдах шаардлага:

Бэлтгэл суурь сургалтад хамрагдсан байх.

3. Сургалтын агуулга:

- Нислэгийн журам зохиох ерөнхий ойлголт
- Эргэлтийн параметр, салхины тооцоолол хийх
- Маршрутын болон хүлээх нислэгийн журам зохиох
- Нисэн ирэх журам зохиох /arrival procedures/
- Ойртолтын эхний хэсэг байгуулах, тооцоолох
- Ойртолтын дунд хэсэг байгуулах, тооцоолох
- Ойртолтын төгсгөлийн хэсэг байгуулах, тооцоолох
- Хоёрдугаар тойрогт гарах журам зохиох
- Нисэн гарах журам зохиох /departure procedures/
- Ил харааны журам зохиох

4. Сургалтын орчин /танхим цахим/:

Танхим

5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:

204 цаг буюу 26 өдөр

6. Анги дүүргэлт:

4-8 суралцагч байна.



Нисэх буудлуудын сумлагч авто машины жолооч нарыг мэргэшүүлэх давтан сургалт

1. Сургалтын зорилго:

Нисэх буудлуудын сумлагч авто машины жолооч нарын мэдлэг чадварыг дээшлүүлж, үүсч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлж, агаарын хөлгийг шатахуунаар цэнэглэх үйл ажиллагааг тасралтгүй хийх, нислэгийн аюулгүй ажиллагааг ханган, олон улсын стандарт шаардлагад нийцсэн үйлчилгээг чанартай хийж гүйцэтгэж сурах

2. Суралцагчдад тавигдах шаардлага:

МУ-ын жолооны үнэмлэхтэй байх, аэродромын маневрлах талбай болон перронд ажиллах жолооч операторчныг мэргэшүүлэх анхан шатны сургалтад хамрагдсан байх

3. Сургалтын агуулга:

- Дүрэм, зураглал, заавар
- Перроны менежмент, аэродромын аюулгүй ажиллагаа
- Аюулгүй ажиллагааны заавар
- Урьдчилан сэргийлэх
- Тусгай тоноглолтой авто машинтай ажиллах аюулгүй ажиллагааны заавар
- Дадлага

4. Сургалтын орчин /танхим цахим/:

Танхим

5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:

42 цаг буюу 6 өдөр

6. Анги дүүргэлт:

15-аас ихгүй суралцагч байна.



Агаарын хөлөг, газрын үйлчилгээний техникчдийн анхан шатны сургалт

1. Сургалтын зорилго:

Суралцагчдад газрын үйлчилгээ хийх үндсэн мэдлэгийг олгох, газрын үйлчилгээний техник, тоног төхөөрөмж дээр ажиллах дадлага туршлагыг олгож, агаарын хөлөг газрын үйлчилгээний мэргэшсэн ажилтнуудыг бэлтгэх.

2. Суралцагчдад тавигдах шаардлага:

Техник мэргэжлийн тусгай дундаас дээш боловсролтой.

3. Сургалтын агуулга:

- Эрх зүй
- Аэродинамик, агаарын хөлөг
- Аэродромын талбайн үйл ажиллагаа
- Аэродром, нисэх буудал
- Перрон дээрх аюулгүй ажиллагааны дүрэм, журам
- Аюул, осол
- Агаарын хөлгийн хөдөлгүүр
- Агаарын хөлөгтэй зөв харьцах
- Гадны биетээс үүсэх гэмтлээс урьдчилан сэргийлэх
- B 737-800, EMB-1458 ERJ-190, ATR-72
- Дадлага ажил
- Тоног төхөөрөмж
- Иргэний нисэхийн аюулгүй байдал
- Аюултай ачаа
- Хүний хүчин зүйл
- Хөдөлмөр хамгаалал, галын аюулгүй байдал

4. Сургалтын орчин /танхим цахим/:

Танхим

5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:

160 цаг буюу 20 өдөр

6. Анги дүүргэлт:

15-20 суралцагч байна.



Агаарын хөлгийн гал унтраах, зорчигчдыг аврах анхан шатны сургалт

1. Сургалтын зорилго:

Агаарын хөлгийн аврагч-гал сөнөөгч мэргэжил шинээр эзэмшиж буй суралцагчдад аэродромын зориулалттай ашиглаж байгаа галын машин, техник хэрэгслийг ажиллуулах, болзошгүй ослын үед түргэн шуурхай алдаагүй ажиллах мэдлэг чадвар, дадлага олгоно.

2. Суралцагчдад тавигдах шаардлага:

Гал унтраах, аврах ажиллагааны дадлага туршлагатай Аврагч-гал сөнөөгч байх,

3. Сургалтын агуулга:

- ИН хууль,
- Нислэгийн онол,
- Нислэгийн хөдөлгөөний удирдлага,
- Нислэгийн мэдээллийн үйлчилгээ,
- Техник хангалт навигацийн үйлчилгээ,
- Аэродром,
- Аюулгүй байдал,
- Аюултай ачаа,
- Агаарын хөлгийн гал унтраах арга зүй,
- Аврах ажиллагааны арга зүй,
- НБ-ын онцгой байдлыг үед ажиллах журам/төлөвлөгөө,
- Дадлага, шалгалт

4. Сургалтын орчин /танхим цахим/:

Цахим/ танхим

5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:

80 цаг буюу 10 өдөр

6. Анги дүүргэлт:

12-иос ихгүй суралцагч байна.



Агаарын хөлгийн гал унтраах, зорчигчдыг аврах давтан сургалт

1. Сургалтын зорилго:

Агаарын хөлгийн гал сөнөөгч, аврагч нарын анхан шатны сургалт болон ажлын дадлагаар олж авсан мэдлэг чадварыг бататгах, галын удирдагч, ослын талбар, хөдөлгөөнт штабын зохицуулагчаар ажиллах мэдлэг олгоход оршино.

2. Суралцагчдад тавигдах шаардлага:

- Агаарын хөлгийн гал унтраах, зорчигчдыг аврах анхан шатны сургалтад хамрагдсан аврагч-гал сөнөөгч байх;
- Аэродромын аврах, гал унтраах албанд 2-оос доошгүй жил ажилласан байх;
- Хоёр жил тутамд нэг удаа сургалтад хамрагдах.

3. Сургалтын агуулга:

- Иргэний нисэхийн аэродром:
- Иргэний нисэхийн галын аюулгүй байдал:
- Агаарын хөлгийн гал унтраах арга зүй:
- Аврах ажиллагааны арга зүй:
- Нисэх буудлын онцгой байдлын үед ажиллах журам:
- Аюултай ачаа:

4. Сургалтын орчин /танхим цахим/:

Цахим/ танхим

5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:

40 цаг буюу 10 өдөр

6. Анги дүүргэлт:

20-иос ихгүй суралцагч байна.



Орон нутгийн нисэх буудлын гал унтраах, зорчигчдыг аврах анхан шатны сургалт

1. Сургалтын зорилго:

Орон нутгийн нисэх буудлын аврах гал унтраах бүлэгт агаарын хөлгийн аврагч-гал сөнөөгч мэргэжил шинээр эзэмшиж буй суралцагчдад аэродромын зориулалттай ашиглаж байгаа галын машин, техник хэрэгслийг ажиллуулах, болзошгүй ослын үед түргэн шуурхай алдаагүй ажиллах мэдлэг, чадвар дадлага олгох.

2. Суралцагчдад тавигдах шаардлага:

- Тухайн нисэх буудлын гал унтраах, аврах ажиллагааны дадлага туршлагатай аврагч-гал сөнөөгч байх
- Галын техник хэрэгслийг чадварлаг эзэмшдэг байх

3. Сургалтын агуулга:

- Иргэний нисэхийн хууль дүрэм
- Нислэгийн онол
- Нислэгийн хөдөлгөөний удирдлага
- Нисэхийн мэдээллийн үйлчилгээ
- Техник хангалт навигацийн үйлчилгээ
- Аэродромын тухай ойлголт
- Аюлгүй байдлын тухай ойлголт
- Аюултай ачааны тухай ойлголт
- Агаарын хөлгийн гал унтраах арга зүй
- Нисэх буудлын онцгой байдлын төлөвлөгөө
- Багаар ажиллах дадлага

4. Сургалтын орчин /танхим цахим/:

Цахим/ танхим

5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:

24 цаг буюу 5 өдөр

6. Анги дүүргэлт:

12-иос ихгүй суралцагч байна.



Орон нутгийн нисэх буудлын агаарын хөлгийн гал унтраах, зорчигчдыг аврах давтан сургалт

1. Сургалтын зорилго:

Хэлипортын талбайн үндсэн мэдлэг олгох, нисдэг тэрэгний газрын үйлчилгээг технологийн дагуу үзүүлэх, богино долгионы станц ашиглах, аюулгүй ажиллагаа, шувууны аюул, эрсдэлийн тухай ойлголт болон болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг Иргэний нисэхийн олон улсын байгууллагын болон Монгол Улсын хууль, дүрэм, журмын хүрээнд хэрэгжүүлэх сургалтад хамруулж мэдлэг, ур чадвар олгох.

2. Суралцагчдад тавигдах шаардлага:

-

3. Сургалтын агуулга:

- Эрх зүйн баримт бичиг, дүрэм журмууд
- Хэлипортын ерөнхий ойлголт
- Хэлипортын талбайн үйл ажиллагаа
- Агаарын навигацийн үйлчилгээ
- Агаарын хөлөг шувуутай мөргөлдөх аюулын тухай ерөнхий ойлголт
- Онцгой байдлын болон гэнэтийн ослын үед ажиллах
- Дадлага

4. Сургалтын орчин /танхим цахим/:

Танхим

5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:

56 цаг буюу 8 өдөр

6. Анги дүүргэлт:

20-иос ихгүй суралцагч байна.



Агаарын хөлгийн аэродромын орчимд шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас урьдчилан сэргийлэх анхан шатны сургалт

1. Сургалтын зорилго:

Агаарын хөлгийг шувуутай мөргөлдөх аюулаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд оролцох нисэх буудлын ажилтанд шувуу, мал амьтны аюул, эрсдлийн тухай ойлголт өгөх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг иргэний нисэхийн ОУ-ын байгууллагын болон МУ-ын хууль, дүрэм журмын хүрээнд хэрэгжүүлэх сургалт, дадлагад хамруулж, мэдлэг ур чадвар олгох.

2. Суралцагчдад тавигдах шаардлага:

Орнитологич инженер, орнитологич техникч, аэродромын ажилтан-шувуу үргээгч, аэродромын үзлэг, аюулгүй ажиллагаа хариуцсан инженер техникийн ажилтан, эсвэл шувууны хяналт, менежментийн үйл ажиллагаанд оролцдог ажилтан байх.

3. Сургалтын агуулга:

- Агаарын хөлөг шувуутай мөргөлдөх аюулын тухай ерөнхий ойлголт
- Эрх зүйн баримт бичиг дүрэм журмууд
- Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй

4. Сургалтын орчин /танхим цахим/:

Цахим/ танхим

5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:

24 цаг буюу 5 өдөр

6. Анги дүүргэлт:

20-иос ихгүй суралцагч байна.



Осол зөрчлийг шинжлэх, шалгах мэдлэг олгох сургалт

1. Сургалтын зорилго:

Иргэний нисэхийн салбарын ажилтнуудад нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаа, хууль эрх зүй, осол зөрчлийн талаар статистик тоо баримттай танилцах.

2. Суралцагчдад тавигдах шаардлага:

- Иргэний нисэхийн салбарын ажилтан байна.
- НСТҮАЕЗ-ын 4.3.3.3 заалтуудыг хангасан байх

3. Сургалтын агуулга:

- Нислэгийн техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах үйл ажиллагаа
- Осол зөрчлийн бүртгэл, судалгаа

4. Сургалтын орчин /танхим цахим/:

Цахим/ танхим

5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:

8 цаг буюу 1 өдөр

6. Анги дүүргэлт:

1-20 суралцагч байна.